“СҮЛД-АУДИТ” ХХК

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

***“КОННЕКТЛАЙФ ДААТГАЛ” ХХК***

***2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан***

Улаанбаатар хот

2026 он

Scanned with CamScanner

# КОННЕКТЛАЙФ ДААТГАЛ ХХК
## 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## АУДИТЫН ДУУСГАВАР БОЛГОСОН ТУХАЙ ТАЙЛАН

***Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:***

"СҮЛД-АУДИТ"
Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 8-р хороо, 11-р хороолол GB center 502 тоот

Утас:70118016
Web: www.suld-audit.mn

Захирал: Ч.Гүндбаяр
Утас: +976 9911-4056
e-mail: info@suld-audit.mn

**Аудиторууд:**
Ч.Гүндбаяр
Б.Долгорсүрэн

АГУУЛГА — ХУУДАС

- Удирдлагын мэдэгдэл 2
- Хараат бус аудиторын дүгнэлт 3
- Аудитлагдсан санхүүгийн тайлан 5
- Аудитын тайлангийн тодруулга 10
- Санхүүгийн тайлангийн тодруулга 15
- Удирдлагад хүргэх захидал 21
- Менежментийн захидал, зөвлөмж 22

2026 оны 3 дугаар сарын 30



Scanned with CamScanner

**КОННЕКТЛАЙФ ДААТГАЛ ХХК**

Хаяг: ЧД, 5-р хороо Самбуугийн гудамж, Тэди төвийн баруун талд Moffice 2 давхар,
Утас: 99105746, 99053896
Имэйл: info@mobilife.mn
Веб хуудас: https://www.mobilife.mn/

2026.03.31 № А-56/2026

танай ____________-ны №_____________-д

**"СҮЛД АУДИТ" ХХК-д**

*Санхүүгийн тайлангийн талаарх удирдлагын мэдэгдэл*

Бид КОННЕКТЛАЙФ ДААТГАЛ ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгыг бүх материаллаг үзүүлэлтүүдээр СТОУС болон Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бэлтгэн толилуулсан болохыг үүгээр баталж байна.

Мөн санхүүгийн тайлантай холбоотой дараах үүргийг Компанийн удирдлага хүлээнэ.

Үүнд:

- Компанийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлж, санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэж, толилуулах;
- Нягтлан бодох бүртгэлийг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хөтлөх;
- Тайлант хугацааны санхүүгийн тайланд компанийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг бүрэн бүртгэж тусгах;
- Тайланд тусгагдсан хөрөнгө, түүний эх үүсвэрийг компанийн өмчлөлд бүрэн бүртгэх ба орхигдуулахгүй байх;

**Хамтын ажиллагаанд талархсан,**

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ** **Б.ЧУЛУУНПҮРЭВ**

КОННЕКТЛАЙФ ДААТГАЛ ХХК
LIFE INSURANCE
УЛААНБААТАР ХОТ
ШТЧ2837 8427976 9025080028

Scanned with CamScanner

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### КОННЕКТЛАЙФ ДААТГАЛ ХХК-ИЙН УДИРДЛАГАД

*Дүгнэлт*

Бид "Коннектлайф Даатгал" Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн (цаашид "Компани" гэх) 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бүхий санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар "Коннектлайф Даатгал" ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Монгол Улсын Аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай, зохистой үндэслэл болно гэж үзэж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлууд гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлийн хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлсэн асуудлууд байдаг. Эдгээр асуудлыг бид санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ тайлангийн талаар аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн бөгөөд аудитор эдгээр асуудлаар тусад нь дүгнэлт өгдөггүй.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт санхүүгийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба санхүүгийн тайланд өгсөн



Scanned with CamScanner

бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

***Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх хариуцлага***

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, үнэн зөв шударгаар толилуулах болон залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайлан бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайлан бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, компанийн чадамжийг үнэлж, тодруулах шаардлагатай бол компанийг татан буулгахаар, эсвэл ингэхээс өөр бодит хувилбар байхгүйгээр төлөвлөснөөс бусад тохиолдолд тасралтгүй ажиллагаатай холбоотой асуудал болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмыг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

***Санхүүгийн Тайлангийн Аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага***

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт ул үндэстэйгээр нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

***Хэрэглээний хязгаарлалт***

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

**СҮЛД-АУДИТ ХХК**

**Ч.ГҮНДБАЯР**
Захирал
ММНБ
2026 оны 3 дугаар сарын 30

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага Тойруу, 8-р хороо, 11-р хороолол, GB Центр #502
И-мэйл: info@suld-audit.mn
Gundbayar@suld-audit.mn
Веб: www.suld-audit.mn
Факс: 976-70118016
Тел: 976-99114056

Scanned with CamScanner

# КОННЕКТЛАЙФ ДААТГАЛ ХХК-ИЙН
# 2025 ОНЫ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

*(төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **ХӨРӨНГӨ** | | |
| **1.1** | **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө** | | |
| 1.1.1 | Бэлэн мөнгө | 79,996 | 69,996 |
| 1.1.2 | Харилцахад байгаа мөнгө | 18,525 | 741,549,522 |
| 1.1.3 | Бусад санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө | - | 2,131,665,714 |
| | **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн дүн** | **98,521** | **2,873,285,232** |
| **1.2** | **Даатгалын авлага** | | |
| 1.2.1 | Даатгалын хураамжийн авлага | - | 127,336,824 |
| | **Даатгалын авлагын дүн** | - | **127,336,824** |
| **1.3** | **Бусад санхүүгийн хөрөнгө** | | |
| 1.3.1 | Бусад авлага | - | 11,576,355 |
| | **Бусад санхүүгийн хөрөнгийн нийт дүн** | - | **11,576,355** |
| **1.4** | **Бусад санхүүгийн бус хөрөнгө** | | |
| 1.4.1 | НДШ-ийн авлага,бусад татварын авлага | - | 136,363,636 |
| 1.4.2 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | - | 5,222,736 |
| | **Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн** | | **141,586,372** |
| **1.5** | **Хөрөнгө оруулалт** | | |
| 1.5.1 | Хадгаламж, хадгаламжийн сертификат | - | 950,923,178 |
| 1.5.2 | Үнэт цаас | - | 1,002,589,041 |
| | **Хөрөнгө орлуулалтын дүн** | | **1,953,512,219** |
| **1.6** | Үндсэн хөрөнгө/Цэвэр/ | - | 8,052,443 |
| **1.7** | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | - | 1,355,113,636 |
| | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **98,521** | **6,470,463,083** |



Scanned with CamScanner

(төгрөгөөр)

| № | Үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **2** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| **2.1** | **ӨР ТӨЛБӨР** | | |
| **2.1.1** | **Даатгалын өглөг** | | |
| 2.1.1.1 | Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг | - | 16,800,945 |
| | **Даатгалын өглөгийн дүн** | - | **16,800,945** |
| **2.1.2** | **Бусад санхүүгийн өр төлбөр** | | |
| 2.1.2.1 | Бусад өр төлбөр | 269,931,367 | 32,079,900 |
| | **Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн** | **269,931,367** | **32,079,900** |
| **2.1.3** | **Бусад санхүүгийн бус өр төлбөр** | | |
| 2.1.3.1 | НДШ-ийн өглөг | 38,982,670 | 4,909 |
| 2.1.3.2 | ААНОАТатварын өглөг | - | 4,084,591 |
| 2.1.3.3 | Урьдчилж орсон орлого | - | 215,166,578 |
| 2.1.3.4 | Бусад санхүүгийн бус өр төлбөр | 17,850,506 | 764,150 |
| | **Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн** | **56,833,176** | **220,020,228** |
| **2.1.4** | **Нөөц сан** | | |
| 2.1.4.1 | Хувь оролцоогүй гэрээний нөөц сан | - | 8,460,732 |
| | **Нөөц сангийн дүн** | - | **8,460,732** |
| | **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | **326,764,543** | **277,361,805** |
| **2.2** | **ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| 2.2.1 | Эздийн өмч | 1,000,000 | 7,001,000,000 |
| 2.2.2 | Хуримтлагдсан ашиг/алдагдал | (327,666,022) | (807,898,722) |
| | **ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **(326,666,022)** | **6,193,101,278** |
| | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **98,521** | **6,470,463,083** |

*/Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно/*

SULD-AUDIT
СҮЛД-АУДИТ
ХХК



Scanned with CamScanner

## КОННЕКТЛАЙФ ДААТГАЛ ХХК-ИЙН
## 2025 ОНЫ ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

*(төгрөгөөр)*

| № | Үзүүлэлт | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **Даатгалын үйл ажиллагаа** | | |
| 2 | Даатгалын хураамжийн нийт орлого | - | 10,410,983 |
| **3** | **Даатгалын хураамжийн цэвэр орлого** | - | **10,410,983** |
| **4** | **Орлогод тооцсон хураамж** | - | **10,410,983** |
| 5 | Хувь оролцоогүй гэрээний нөөц сангийн өөрчлөлт | - | 8,460,732 |
| **6** | **Зардалд тооцсон нөхөн төлбөр** | - | **8,460,732** |
| 7 | Хөрөнгө оруулалтын орлого | - | 251,197,147 |
| **8** | **Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)** | - | **253,147,398** |
| 9 | Түрээсийн орлого | - | 22,758,685 |
| 10 | Бусад орлого | - | 332,950 |
| 11 | Ерөнхий ба удирдлагын зардал | 310,043,775 | 730,634,003 |
| 12 | Бусад зардал | 16,508,747 | 439,373 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарз | - | (278,642) |
| 14 | Бусад ашиг (алдагдал) | (1,000,000) | - |
| **15** | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **(327,552,522)** | **(455,112,985)** |
| 16 | Орлогын албан татварын зардал | - | 25,119,715 |
| **17** | **Татварын дараах ашиг (алдагдал)** | **(327,552,522)** | **(480,232,700)** |
| 18 | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг(алдагдал) | - | - |
| 19 | **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)** | **(327,552,522)** | **(480,232,700)** |
| 20 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | - | - |
| **21** | **Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү** | - | - |
| 22 | Бусад | - | - |
| **23** | **Орлогын нийт дүн** | **(327,552,522)** | **(480,232,700)** |
| 24 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | - | - |

*/Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно*

SULD-AUDIT
СҮЛД-АУДИТ
ХХК
Co. Ltd



Scanned with CamScanner

## КОННЕКТЛАЙФ ДААТГАЛ ХХК-ИЙН
## 2025 ОНЫ ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

*(төгрөгөөр)*

| № | ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| 1 | 2024 оны 01-р сарын 01 -ний үлдэгдэл | **1,000,000** | **(113,500)** | **886,500** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - |
| 3 | **Залруулсан үлдэгдэл** | 1,000,000 | (113,500) | 886,500 |
| 4 | Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал ) | - | (327,552,522) | **(327,552,522)** |
| 5 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - |
| 6 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - |
| 7 | Зарласан ногдол ашиг | - | - | - |
| 8 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - |
| 9 | **2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | 1,000,000 | (327,666,022) | **(326,666,022)** |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - |
| 11 | Залруулсан үлдэгдэл | 1,000,000 | (327,666,022) | **(326,666,022)** |
| 12 | Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал ) | - | (480,232,700) | **(480,232,700)** |
| 13 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - |
| 14 | Өмчид гарсан өөрчлөлт | 7,000,000,000 | | 7,000,000,000 |
| 15 | Зарласан ногдол ашиг | - | - | - |
| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - |
| 17 | **2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **7,001,000,000** | **(807,898,722)** | **6,193,101,278** |

*/Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно/*

SULD-AUDIT СҮЛД-АУДИТ ХХК



Scanned with CamScanner

# КОННЕКТЛАЙФ ДААТГАЛ ХХК-ИЙН
# 2025 ОНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

*(төгрөгөөр)*

| № | ҮЗҮҮЛЭЛТ | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 1.1 | **Мөнгөн орлогын дүн (+)** | - | **163,452,555** |
| 1.1.1 | Даатгалын хураамжийн орлого | - | 83,475,498 |
| 1.1.2 | Бусад мөнгөн орлого | - | 79,977,057 |
| 1.2 | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **208,453,680** | **510,679,689** |
| 1.2.1 | Ажилчдад төлсөн | 183,802,053 | 209,380,769 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 18,392,000 | 112,673,577 |
| 1.2.3 | Хүүний төлбөрт төлсөн | - | - |
| 1.2.4 | Татварын байгууллагад төлсөн | 2,000,000 | 62,742,421 |
| 1.2.5 | Бусад мөнгөн зарлага | 4,259,627 | 125,882,922 |
| 1.3 | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(208,453,680)** | **(347,227,134)** |
| 2 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 2.1 | **Мөнгөн орлогын дүн (+)** | **1,247,500** | **253,504,634** |
| 2.1.1 | Хүлээн авсан хүүний орлого | - | 253,504,634 |
| 2.2 | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **2,853,000** | **1,556,915,890** |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | 1,513,420,000 |
| 2.2.2 | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | 2,853,000 | 43,495,890 |
| 2.3 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(1,605,500)** | **(1,303,411,256)** |
| 3 | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 3.1 | **Мөнгөн орлогын дүн (+)** | **210,157,701** | **10,000,000,000** |
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 210,157,701 | 3,000,000,000 |
| 3.1.2 | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас | - | 7,000,000,000 |
| 3.2 | **Мөнгөн зарлагын дүн (-)** | - | **5,476,174,899** |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн | - | 5,476,174,899 |
| 3.3 | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **210,157,701** | **4,523,825,101** |
| **4** | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | **98,521** | **2,873,186,711** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **0** | **98,521** |
| **6** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **98,521** | **2,873,285,232** |

*/Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно/*

SULD-AUDIT
СҮЛД-АУДИТ
ХХК
Co.,Ltd



Scanned with CamScanner